



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 047

Жавхлант

Хөрөнгийг бүртгэж, зарлагадах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.1.6, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 1.3.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Онцгой комиссоос үнэ төлбөргүй олгосон бараа материалыг Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж зах зээлийн ханшаар үнэлгээ тогтоолгон бараа материалын хөрөнгөнд бүртгэн авч, зарлагадахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Оюунчимэг), Нягтлан бодогч (С.Наранцэцэг) нарт даалгасугай.
2. Төрийн байгууллагын бараа материалын хөрөнгөнд бүртгэн авах хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Т.Эрдэнэцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТЧУЛУУН